



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 29 дэх долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 7-р сарын 10-аас 7-р сарын 16-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 18 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Oxford Economics** байгууллагаас дэлхийн эдийн засгийн төлөвийг өмнөх сарын төсөөллөөс 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж **2020 онд 4.5 хувиар агших** төсөөллийг 7-р сард шинэчлэн боловсрууллаа. Төсөөллийг өмнөх сараас сайжруулахад Европ, АНУ зэрэг хөгжингүй орнуудад хэрэглээ, жижиглэн худалдаа төсөөлснөөс хурдтай сэргэж, АНУ, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв сайжирсан нь нөлөөлжээ. Суурь төсөөлөлд БНХАУ-ын эдийн засаг 2.0 хувиар өсөх, Евро бүсийн эдийн засаг 7.9 хувиар, АНУ-ын эдийн засаг 4.2 хувиар тус тус агшихаар таамаглажээ. Гэхдээ цар тахлын хоёр дахь давалгаа бий болох тохиолдолд дэлхийн эдийн засгийн төлөв муудах эрсдэлтэйг онцлов.
- **Хэрэглээний зарцуулалт нэмэгдсэнээр Евро бүсийн эдийн засаг сэргэж байна.** Жижиглэн худалдаа 5-р сард өмнөх сараас эрчтэй сэргэж, өнгөрсөн оны мөн үеэс ердөө 5 хувиар бага түвшинд хүрээд байна. Тухайлбал, бүсийн жижиглэн худалдаа 3-р сард 10.6 хувиар, 4-р сард

12 хувиар тус тус агшсан бол 5-р сард өмнөх сараас 17.8 хувиар өслөө. Үүнд нэхмэл материал, хувцас, гутлын худалдаа 5-р сард өмнөх сараас 147 хувиар өссөн нь гол хувь нэмэр оруулжээ. Мөн тавилга болон электрон бараа, компьютерийн хэрэгслийн худалдаа өмнөх сараас 38 хувиар өссөн байна. 2019 оны сүүлийн улиралд 12.7 хувь байсан өрхийн хадгалах хувь 2020 оны 1 улиралд 16.9 болж нэмэгдсэн дүнтэй байна.

- **Цар тахлын улмаас ихээхэн хохирол амссан үйлчилгээний салбарууд сэргэж эхэллээ.** Дэлхийн үйлчилгээний салбарын нэгдсэн PMI индекс 5-р сард 35.1 байсан бол 6-р сард 48 болж агшилт нь багасав<sup>1</sup>. Дэд бүлгээр авч үзвэл зах зээлийн хүлээлтийн индекс өссөн боловч дэлхийн нийтийн худалдааны эргэлт буурснаар экспортын захиалга муудсан дүнтэй байна. Улс, бүс нутгаар авч үзвэл, АНУ-ын үйлчилгээний PMI индекс 5-р сард 37.5 байсан бол 6-р сард 47.9, Евро бүсийн PMI индекс 5-р сард 30.5 байсан бол 6-р сард 48.3, Азийн

<sup>1</sup> PMI индекс 50-аас доош утгатай байх нь тухайн салбар агшсаныг, 50-аас дээш утгатай байх нь тухайн салбар өсөлттэй байгааг илтгэдэг. Үйлчилгээний салбарын төлөвийг тодорхойлогч PMI индекс нь

үйлдвэрлэл (output), экспортын захиалга, ажил эрхлэлт, үнэ, зах зээлийн хүлээлтийн индекс гэсэн дэд индексүүдээс бүрддэг.

бүсийн PMI индекс 5-р сард 12.6 байсан бол 6-р сард 33.7 болж тус тус өссөн буюу 6-р сард үйлчилгээний салбарын агшилт эрс багассан байна.

- **Японы Төв банк** 7-р сарын 15-ны өдрийн хурлаар бодлогын хүүгээ **-0.1 хувьд, 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөжийг 0 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.** Энэ үеэр Японы Улсын эдийн засаг 2020 оны II улиралд алгуур сэргэж, 2020 онд 4.7 хувиар агшиж, 2021 онд 3.3 хувиар өсөхөөр төсөөлж байгааг мэдэгдлээ. Тус улсын ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци энэ онд 0.5 хувиар буурах бол ирэх жил 0.3 хувиар өсөхөөр байгаа аж. Саяхан Токио хотод Ковид-19 цар тахлын халдвар дахин гарсан ч халдварыг үндэсний хэмжээнд хүргэхгүй, хоёр дахь давлагаа гарахгүй гэж үзэж байна. Цар тахлын үед тус улсын Төв банк хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл ихээр олгох зэрэг бодлогын хэрэгслүүдийг голчлон ашиглаж байна.
- **Сингапур Улсын экспорт 6-р сард хүлээлтээс давж** өмнөх сараас 0.5 хувиар өссөн<sup>2</sup> бөгөөд газрын тосыг хасч тооцвол бусад экспорт жилийн 16.1 хувиар **өслөө.** Үүнд электрон барааны экспорт 22.2 хувиар, эм, эмийн бүтээгдэхүүн 30.8 хувиар, мөнгөжөөгүй алт 2.4 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Сингапур Улсын эдийн засаг сүүлийн 3 сард жилээр 41.2 хувиар агшиж, өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 2-р улиралд 12.6 хувиар агшсаныг Сингапурын Худалдаа, Аж үйлдвэрийн яамнаас мэдээллээ.

- **АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны тайлан тэнцэл хумигдах төлөвтэй байна.** ХНБ-ны тайлан тэнцэл 7-р сарын 15-ыг хүртэлх 7 хоногт 7 их наяд ам.долларт хүрсэн нь өмнөх 7 хоногоосоо бага зэрэг өссөн боловч өмнөх сараас 210 тэрбум ам.доллараар буурчээ. Төв банкны тайлан тэнцэл 2020 оны эхнээс 71 хувиар өсөөд байсан бол аажмаар буурч, 3-р сараас хойш Ковид-19-ийн улмаас эдийн засгийг дэмжих яаралтай багц хөтөлбөрүүдийн хэрэгцээ аажмаар буурч байгааг харуулж байна гэж “Wall Street”-ийн эдийн засагчид үзэж байна. 2020 оны 28 дугаар долоо хоногт ХНБ репо арилжаанд оролцоогүй байна. Иймд эдийн засагчид ХНБ-ны тайлан тэнцлийн төсөөллийг 1 их наяд ам.доллараар буурууллаа.

#### *Эх сурвалж:*

1. Deloitte, [Weekly global economic update July 2020](#)
2. Continuum Economics, [Bank of Japan on Hold, Expects Moderate Recovery in H2](#)
3. Oxford economics, [World Economic Prospects Monthly](#)
4. Bloomberg, [Singapore Slumps Into Recession With Record 41.2% GDP Plunge](#)
5. Bloomberg, [Singapore's June Exports Jump at Faster Pace Than Forecast](#)
6. Bloomberg, [China's Rebounding Economy Now Hinges on Global Recovery](#)
7. Financial times, [Wall Street cuts forecasts for Fed balance sheet growth](#)

<sup>2</sup> Блүүмбергийн эдийн засагчид Сингапурын экспорт 6-р сард 4.6 хувиар агших хүлээлттэй байв.

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын эдийн засаг 2-р улиралд жилийн 3.2 хувиар өсөв<sup>3</sup>.** Өсөлтөд аж үйлдвэрлэл, төсвийн зарцуулалт нэмэгдсэн, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт болон жижиглэн худалдааны агшилт оны эхний улиралтай харьцуулахад саарсан нь голлон нөлөөлөв.
- Аж үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл 5, 6-р сард өмнөх оны мөн үеэс 4.4 хувь, 4.8 хувиар тус тус нэмэгдэв. Аж үйлдвэрлэлийн өсөлтийг бүрэлдэхүүнээр нь задалж харвал төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл сүүлийн 2 сар дараалан нэмэгдэж 6-р сард 4.9 хувиар өссөн. Харин хувийн өмчит аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл 4-5-р саруудын 7 хувиар өсч байсан бол 6-р сард 4.8 хувиар өсөв. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн өсөлт 3 сар дараалан хадгалагдаж, автомашины үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар тэлсэн нь өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв.
- Үл хөдлөх салбар дахь хөрөнгө оруулалт оны эхний 5 сард 6.3 хувиар буурч байсан бол оны эхний хагаст 3.1 хувиар буурч агшилт багасав. Үүнд эдийн засгийг дэмжих бодлогын нөлөөгөөр **төсвийн хөрөнгө оруулалт** оны эхний хагаст 2.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Оны эхний 5 сард 9.6 хувиар агшсан хувийн секторын хөрөнгө оруулалт оны эхний хагаст 7.3 хувиар буурч мөн агшилт нь багасав. Дийлэнх салбарууд дахь хөрөнгө оруулалт оны эхний хагаст бууралт хадгалагдсан бол эрүүл мэндийн салбар, мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтууд нэмэгджээ.
- **Жижиглэн худалдаа** 6-р сард өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар буюу хүлээлтээс бага буурав. Үүнд хэрэглээний үндсэн бүтээгдэхүүнүүд, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, эмийн худалдан авалт 6-р сард хүлээлтээс давж өссөн нь нөлөөлөв. Харин зайлшгүй бус бусад хэрэглээнд орох кетеринг үйлчилгээний борлуулалт өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, автомашины борлуулалт 8.2 хувиар тус тус буурчээ.
- **Ажилгүйдлийн түвшин** 5-р сард 5.9 хувьд хүрсэн бол 6-р сард 5.7 хувь хүрч бага зэрэг буурах хандлагатай байна.
- **БНХАУ-ын Ардын банк** бодлогын хүүгээ энэ онд дахин 40 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан бол эдийн засаг өмнөх төсөөлөлтэй харьцуулахад тогтворжиж буй учир оны эцэст 20 нэгж хувиар бууруулах хүлээлттэй боллоо.
- **БНХАУ-ын 1-р зэрэглэлийн хотуудын /Бээжин, Шанхай, Гуангжоу, Шенжен/ орон сууцны худалдаа** 6-р сарын 19-ны байдлаар цар тахлын өмнөх үеэс 14 хувиар нэмэгдсэн ч 7-р сарын 3-ны өдөр эргэж 21 хувиар буурчээ. Энэ нь БНХАУ-ын томоохон хотуудад үл хөдлөх хөрөнгийн борлуулалт алгуур нэмэгдэж байсан хэдий ч хэрэглэгчдийн итгэл хараахан хангалттай сэргэх болоогүй байгааг илтгэж байна.
- **Гадаад худалдааны тэнцлийн ашиг** 6-р сард өмнөх сараас буурч, төсөөллөөс доогуур гүйцэтгэлтэй гарлаа. БНХАУ-ын экспорт 6-р сард 0.5 хувиар, импорт 2.7 хувиар өсчээ. Улмаар БНХАУ-ын

<sup>3</sup> Харин Блүүмберг Экономиксийн 3.4 хувиар өсөхөөр төсөөлж байсан.

худалдааны тэнцэл 6-р сард 46.4 тэрбум ам.долларын ашигтай гарав. **Экспорт** хүлээлтээс өндөр өсөлттэй гарсан нь Зүүн Өмнөд Азийн орнууд, АНУ руу экспортлох бараа, бүтээгдэхүүн 6-р сард өмнөх оны мөн үеэс 1.6 хувь, 1.4 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой. Экспортын өсөлтийг бүрэлдэхүүнээр задалж харвал эрүүл мэндийн багаж хэрэгслийн экспорт нэрлэсэн дүнгээрээ өмнөх жилийн түвшнээс 2 дахин, нэхмэл утас, бөс даавууны /маск багтана/ тээвэрлэлт 56.7 хувиар тус тус нэмэгдэв. Түүнчлэн экспортын уламжлалт бүтээгдэхүүн болох тавилга, цахилгаан гэрэлтүүлгийн экспорт мөн 8.4 хувь, 9.9 хувиар тус тус өслөө. Харин хүүхдийн тоглоом, гутал, хувцасны экспортын бууралт хадгалагдав.

- **Голлох түүхий эдийн импорт** нэрлэсэн дүнгээр өсөв. Түүхий нефтийн импорт өмнөх оны мөн үеэс 34.4 хувь, төмрийн хүдрийн импорт 35.3 хувиар тус тус өсөв. Үүний зэрэгцээ БНХАУ-ын буурцагны импорт өмнөх оны мөн үеэс 71.4 хувиар өсөв. Засгийн газраас тус импортын эх үүсвэрийг зарлаагүй ч дийлэнх хэмжээг АНУ-аас импортолсон байх магадлалтай байгаа нь БНХАУ-ын талаас худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд анхаарч байгааг илтгэж байна.

### *Эх сурвалж:*

1. Bloomberg, China React: GDP growth over 3% solace, new clouds gather
2. Bloomberg, China React: Upside trade surprise bodes well for recovery, Bloomberg
3. Bloomberg, China Insight: Virus in check, demand still weak-dashboard,
4. Bloomberg, China Preview: Export decline likely narrowed in June, Bloomberg
5. Bloomberg, China Commodities Today

### 3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Долоо дугаар сард төлөвлөөд байсан 12 нислэг дээр нэмж Австрали руу 1, БНСУ-руу шууд 1, транзит нислэг 1-ийг тус бүр үйлдэж, 690 иргэнээ нэмэлтээр татахаар боллоо. Ингэснээр долдугаар сард 15 удаагийн нислэгээр 3400 иргэнийг эх оронд нь авч ирэх юм.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 55 улсаас 10,513 Монгол Улсын иргэн эх орондоо ирэх хүсэлтээ УОК-ын шуурхай штабт албан ёсоор гаргаад байна. Тэдний 1800 нь бага насны хүүхэдтэй гэр бүл, 740 өвчний магадлагаатай, 797 нь өндөр настан, 240 гаруй нь жирэмсэн, 1553 нь оюутан, 131 нь богино хугацааны визээр сургалтад хамрагдсан насанд хүрэгч, 13 нь хүүхэд бусад 4300 гаруй иргэн байна. УОК-иос хүсэлт гаргасан эдгээр иргэдээ богино хугацаанд эрчимтэй татаж авах зорилготой ажиллаж байгаа бөгөөд наймдугаар сард нэмэгдүүлэхээр зорьж байгаа аж. Тусгаарлах байрыг нэмэгдүүлэхээр нийслэл болон ойр орчмын нийт 215 зочид буудал, 45 амралтын газарт судалгаа хийхэд 24 хувь нь инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, 25 хувь нь гал тогоогүй гэх зэргээр халдвар хамгааллын шаардлага дэглэмд нийцэхгүй хүндрэл бэрхшээл тулгараад байна. Мөн ОУ-ын зэрэглэл бүхий өндөр үнэтэй зочид буудлуудад иргэдийн сонголтоор байрлуулж болох эсэх талаар судлахад тухайн байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг хэсэгчлэн мөрдүүлэх ямар ч нөхцөл боломжгүй нь тогтоогджээ. Тиймээс тодорхойлогдсон нөхцөл боломждоо тулгуурлаж татан авалтаа үргэлжлүүлнэ. Монгол Улсын хувьд уг өвчний 227 тохиолдол зөөвөрлөгдөн орж ирж бүртгэгдсэнээс

195 нь эмчлэгдэж, 32 хүн эмчлүүлж, 3077 хүн тусгаарлалтад байна. Батлагдсан тохиолдлын 84 хувь нь ОХУ-д сурч, амьдарч байсан иргэдээс илэрсэн.

Хилийн хорио цээрийн дэглэм нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш дэлхийн 44 орноос 67,290 Монгол Улсын иргэнийг эх орондоо агаарын, газрын, төмөр замын тээврээр татан аваад байна. Захиалгат нислэгт эхний ээлжинд багтах иргэдэд тавигдах шаардлагуудыг өргөжүүлж, богино хугацааны сургалтын визээр гадаадад зорчсон иргэн, оюутан, амьжиргааны зардалгүй хүнд нөхцөлд орсон иргэдийг хамруулж байна.

УОК, УОК-ын Шуурхай штабаас гадаад дахь иргэдээ татан авах ажиллагааг эрчимжүүлж байгаа ч дотооддоо халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийт иргэдийн амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг нэгдүгээрт тавьж байна. Иймд халдвар хамгааллын дэглэмийг чангатгаж, иргэдийн гомдол, цахим орчинд тархааж буй мэдээллийг нягталсны үндсэн дээр, эрдэмтэн судлаачид, ОУ-ын эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөмжийг дагаж, тусгаарлах 21 хоногийг бууруулахгүйгээр шийдвэрлэв.

Гадаад дахь иргэдийг татан авахтай холбогдуулан УОК-ын Шуурхай штабт 13,000 гаруй өргөдөл гомдол, мэдээлэл ирсэн байна. Иймд татан авалтын үйл явцыг иргэдэд ил тод нээлттэй болгох менежментийн өөрчлөлт хийхээр болжээ. Үүнд гомдол мэдээлэл бүрт

хариу өгч шийдвэрлэх, нийтэд зарлах, Гадаад дахь дипломат байгууллагуудад иргэдийн гаргасан хүсэлт, дарааллыг тухайн байгууллагууд ямар нэг хэлбэрээр ил тод байрлуулах, иргэн өөрийн дарааллыг харах боломжтой болгохыг УОК-иос шаардаж, ажиллах аж. Иргэд УОК-ын ШШ-ын 18001105, 318277, 223454 дугаарын утсаар гомдол мэдээлэл өгөх боломжтой юм.

**Эх сурвалж:**

Монгол Улсын Засгийн газар, [Гадаад дахь иргэдээ татан авахаар энэ сард нэмэлт гурван нислэг үйлдэнэ](#)

## 4 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

### USD, S&P:

- Тайлант хугацаанд ам.доллар голлох валютын эсрэг 1.2%-иар сулран 95 түвшинд хүрч уналаа.
- S&P 500 индексийн хувьцааны үнэ, орлогын харьцаа 2000 болон 2007-2009 оны хямралын өмнөх үеийн хөрөнгийн захын хөөсрөлтийн түвшинд эргэн ирэв. Гэхдээ хувьцааны ханшийн энэхүү өсөх хөдөлгөөн нь компаниудын санхүүгийн үзүүлэлт болон бодит эдийн засгийн нөхцөл байдал зэрэгтэй огт холбоогүй юм.
- Улмаар энэхүү хөөрөгдөл ойрын хугацаанд огцом буурч үнийн хөдөлгөөний тохируулга хийгдэх төлөв өндөр байна.

Дүрслэл 1: S&P 500 индекс P/E харьцаа



### GBP, FTSE:

- Тайлант хугацаанд фунт стерлинг ам.долларын эсрэг 0.7%-иар чангарч, 1.26 түвшинд хүрлээ.

### JPY, Nikkei:

- Тайлант хугацааны эцэст иен ам.долларын эсрэг 0.5%-иар чангарч 107.02 түвшинд хүрлээ.
- Макро эдийн засгийн үзүүлэлт муудсан хэдий ч коронавирусийн вакцин, 2021 онд эдийн засаг эргэн сэргэх хүлээлт зэрэг нь хувьцааны зах зээлд эерэгээр нөлөөлөв.

### EUR:

- Тайлант хугацаанд евро ам.долларын эсрэг 1.6%-иар чангарч, 1.14 түвшинд хүрлээ.
- Евро бүсийн удирдагчид 3 хоногийн турш бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжих санхүүгийн багц арга хэмжээний талаар хэлэлцэв. Зах зээлд оролцогчдын зүгээс хэлэлцээрийн үр дүнгийн талаар эерэг хүлээлттэй байгаа нь ханшийн өсөлтөд эерэгээр нөлөөлж байна.

### CNY:

- БНХАУ-ын эдийн засаг идэвхжиж, гадаад худалдаа сайжирснаар юанийн эрэлт нэмэгдэж тайлант хугацаанд юань ам.долларын эсрэг 1.1%-иар чангарч 6.99-д хүрлээ.
- Мөн тус эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр Hang Seng болон Шанхайн нэгдсэн индексүүд өмнөх сараар 5.7% болон 11.0%-иар тус тус өслөө.



**5 ХҮҮ, БОНД, ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАГДАЖ БУЙ МУ-ЫН БОНД, ХУВЬЦАА**

**LIBOR:**

- Богино хугацаат буюу 1 сар хүртэлх LIBOR хүү өсөлттэй байсан бол 3-аас дээш сарын хугацаатай хүү 2-6 суурь нэгжээр буурав. Улмаар хүүгийн муруй шулуун болох шинж ажиглагдаж байна.

**АНУ-ЫН ЗГҮЦ:**

- Хүүний түвшин доогуур байгаа нь ХО-ыг урт хугацаатай, эрсдэл өндөр, эсвэл өөр төрлийн актив (хувьцаа г.м.)-д хөрөнгөө байршуулахад хүргээд байгаа.
- ХНБ-ны хэрэгжүүлж буй актив хязгааргүй хэмжээгээр худалдан авах хөтөлбөр нь бондын хүүний түвшинг тогтвортой барьж байна.

Хүснэгт 1: Голлох хүүгийн өөрчлөлт

Индекс	Сүүлийн хаалт	14 хоног Δ	1 сар Δ	1 жил Δ	Оны эх Δ
Fed Overnight	0.08	▲ 0.00	▲ 0.00	▼ -2.29	▼ -1.47
Libor 1 week	0.11	▲ 0.01	▼ 0.00	▼ -2.26	▼ -1.48
Libor 1 month	0.19	▲ 0.02	▼ -0.01	▼ -2.11	▼ -1.55
Libor 3 month	0.27	▼ -0.03	▼ -0.04	▼ -2.03	▼ -1.63
Libor 6 month	0.34	▼ -0.02	▼ -0.09	▼ -1.86	▼ -1.57
Libor 12 month	0.48	▼ -0.06	▼ -0.11	▼ -1.74	▼ -1.52
Shibor O/N	2.33	▲ 0.96	▼ -0.18	▼ -0.38	▲ 0.88
Shibor 1 Week	2.23	▲ 0.25	▼ -0.38	▼ -0.51	▼ -0.21
Shibor 1 Month	2.20	▲ 0.19	▼ -0.61	▼ -0.36	▼ -0.70
Shibor 6 Month	2.44	▲ 0.26	▼ -0.46	▼ -0.26	▼ -0.58
Shibor 1 Year	2.64	▲ 0.26	▼ -0.34	▼ -0.46	▼ -0.45
US 2Y Treasury	0.15	▼ -0.01	▼ -0.04	▼ -1.67	▼ -1.42
US 10Y Treasury	0.63	▼ -0.04	▼ -0.07	▼ -1.42	▼ -1.25
Japan 2Y Treasury	-0.15	▼ -0.01	▲ 0.01	▲ 0.04	▼ -0.02
Japan 10Y Treasury	0.01	▼ -0.01	▲ 0.00	▲ 0.14	▲ 0.03
Bund 2Y Treasury	-0.67	▲ 0.02	▲ 0.01	▲ 0.08	▼ -0.06
Bund 10Y Treasury	-0.45	▼ -0.02	▼ -0.03	▼ -0.16	▼ -0.22
ECNIA	-0.46	▲ 0.01	▲ 0.01	▼ -0.09	▼ 0.00

**SHIBOR:**

- Тайлант хугацаанд SHIBOR хүү бүх хугацаанд 19-96 суурь нэгжийн өсөлттэй байж, эргэн сэргэв. Гэсэн ч SHIBOR хүү оны эхнээс бүх хугацаанд овернайтаас бусад хугацаанд 45-90 суурь нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

**Бондын мэдээлэл:**

- Тайлант хугацаанд Монгол Улсын гадаад бондуудын үнэ 9% хүртэл өсч, өгөөжийн түвшин 3.6% хүртэл буурав.
- Ийнхүү Монгол Улсын ам.долларын ҮЦ-ны өгөөж буурч, үнэ өсч буй нь хөрөнгө оруулалтын орчин сайжирч, зээлийн эрсдэл буурч байгааг илтгэж байна.

Хүснэгт 2: Дотоодын үнэт цаасны өөрчлөлт

Үнэт цаас	Сүүлийн хаалт	Өөрчлөлт Δ			
		14 хоног	Сар	Жил	Оны эх
ЗГҮЦ 5 жил	\$113.3	▲ 9.0%	▲ 8.5%	▲ 2.0%	▼ -4.4%
ЗГҮЦ 10 жил	\$100.2	▲ 0.4%	▲ 0.4%	▼ -1%	▼ -2%
ЗГҮЦ 5 жил (2021)	\$104.5	▲ 0.5%	▲ 0.1%	▼ -6%	▼ -4.4%
ЗГҮЦ 7 жил	\$109.2	▲ 0.8%	▲ 1.4%	▼ -3.5%	▲ 0.8%
ЗГҮЦ (Гэрэгэ)	\$100.7	▲ 0.3%	▲ 0.7%	▼ -1.4%	▼ -2.8%
ХБ 5 жил (2023)	\$101.4	▲ 5.2%	▲ 5.9%		
Turquoise hills (CAD)	\$0.8	▲ 7.3%	▲ 18%	▲ 30%	▲ 8.1%
ММС (HKD)	\$0.5	▲ 12.8%	▲ 43%	▼ -55%	▼ -26.5%
<b>Өгөөж</b>					
ЗГҮЦ 10 жил (Чингис)	5.0	▼ -0.19	▼ -0.20	▲ 0.27	▲ 0.85
ЗГҮЦ 5 жил (Мазаалай)	3.6	▼ -0.92	▼ -0.76	▼ -0.26	▲ 0.68
ЗГҮЦ 7 жил (Хуралдай)	5.9	▼ -0.29	▼ -0.49	▲ 0.42	▲ 0.91
ЗГҮЦ 6 жил (Гэрэгэ)	5.3	▼ -0.10	▼ -0.27	▲ 0.36	▲ 0.89
ХБ 5 жил (2023)	7.6	▲ 0.00	▲ 0.00		